



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 05 өдөр

Дугаар А/04

Мандалговь

Газар эзэмших зориулалт  
өөрчлөх тухай

Монгол улсын Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх заалт, Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журмын 3.1.5 дах заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Сайнцагаан сумын төвийн 7 дугаар багийн нутаг дэвсгэрт (Ж.Пэлжээгийн гудамж-2-222 тоот хаягт) байршилтай Дундговь аймгийн Тагнуулын хэлтэс (РД:9033718)-ийн төрийн байгууллагын зориулалттай 1755м<sup>2</sup>(0.1755 га) газрын зориулалтыг өөрчилж, нийтийн орон сууцны зориулалттай болгож, 17 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

Хоёр. Дээрх байгууллагатай газар эзэмших гэрээ, гэрчилгээг шинэчлэн байгуулахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү захирамж гарсантай холбогдуулж аймгийн Засаг даргын 2013 оны А/311 дүгээр захирамжийн Дундговь аймгийн Тагнуулын хэлтэст холбогдох хэсэг, газар эзэмших (000005654) тоот гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.МӨНХБАТ

481210002